



# СОЁМБОМ

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ

# МЭДЭЭ

№182 /392/

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

2022.10.11

Сурвалжилга

## ХАЛАГДААД ААВ, ЭЭЖДЭЭ ТУСАЛЖ, МАЛАА МАЛЛАНА



Зэвсэгт хүчин, Хилийн цэрэг, Дотоодын цэргийн тэргүүний хугацаат цэргийн алба хаагчдын дунд явагдсан "Цэргийн мэргэжлийн аварга түрүүч, байлдагч"-ийн тэмцээнд орон нутгийн нэгтгэл, ангиудаас цөөнгүй залуус ирсний нэг нь Зэвсэгт хүчний 256 дугаар ангийн байлдагч Х.Энхбаяр, дэд түрүүч Ш.Эрдэнэсайхан нар байв.

Дэд түрүүч Ш.Эрдэнэсайхан Архангай аймгийн Өндөр-Улаан сумынх. Аав О.Шарамжамц, ээж Б.Буянжаргал нь нутагтаа мал маллан амьдран суугаа, ажилсаг хөдөлмөрч хүмүүс гэнэ. Нэгхэн жилийн өмнө цэргийн албаны талаар ойлголтгүй, нутгийнхаа залуустайгаа ирж байсан бол өнөөдөр цэргийн хуарандаа, ижил дасал болсон нөхдөдөө, цэргийн дарга нартаа хорогдох мэдрэмж ихээр төрж байна. Цэргийн албанаас авсан эрдмээ тоочвол хэмжээлшгүй. Хувийн зохион байгуулалтаа сайжруулахаас эхлээд

эх орныхоо үнэ цэнийг мэдэрсэн цаг хугацаа болж өнгөрснийг дэд түрүүч онцлон өгүүлэв. Тэрээр халагдаад инженерийн чиглэлээр суралцах төлөвлөгөөтэй бөгөөд эхний хоёр жилдээ аав, ээждээ хань болж мал ахуйг нь хариуцаж, тэднийгээ бага ч болов амраах гэнэ. Аав, ээжийгээ л хамгаас их санасан, уулзах өдрөө тэсэн ядан хүлээж буйгаа дурдаад орчин цагийн Зэвсэгт хүчний 100, 101 жилийн ойн түүхэн жилд алба хааснаа их хувь заяа гэж тодотголоо.

Түүний хамт ангиасаа дөрөө харшуулан ирсэн байлдагч Х.Энхбаяр Баянхонгор аймгийн Богд сумын харьяат. Сумаасаа гурвуулаа алдар түүхт танкны тусгай хороонд ирж, цэргийн алба хаасан гэнэ. Цэрэгт ирэхээс өмнөх Х.Энхбаяр, ирсний дараах Х.Энхбаяр хоёрт асар их ялгаатай. Ядаж л юмны учрыг ололгүй уурлаж, зөрүүдэлдэг сул талтай байсан бол цэрэгт ирснээр хүлээцтэй

байх, бусдыг хүндлэхэд өөртөө том өөрчлөлт авчирсан гэж байна. Цэргийн алба хааж байхдаа хамгийн мартагдашгүй үе гэвэл Зэвсэгт хүчний "Марш-тусгай бэлтгэлийн цогцолбор" тэмцээнд оролцож байсан, буудлага хийж байсан үеүд гэнэ. Халагдаад малаа маллана. Түүний аав Б.Хүрэлтогоо, ээж Р.Дуламханд нартаа цэрэг хүний ёсоор илтгэнэ. Аав маань залуудаа Зэвсэгт хүчний 032 дугаар ангийн хугацаат цэргийн алба хааж байсан болохоор хүүгээрээ маш их бахархаж байгаа гэдэгт итгэж байна гэв. Мөн тэрээр хуучин цагт сумын ах нар цэргээс ирэхэд нутгаараа л баярлаж, бахархаж байгаа харагддаг сан. Тэр үед хүүхэд байсан болохоор төдийлөн тоогоогүй. Харин өнөөдөр өөрөө нутгийнхныхаа тэр бахархал дунд очно гэж бодохоор сайхан байна гэсэн юм.

### ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 13	☁️ -3

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 32	☁️ 23

### ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD 🇺🇸	3.460.00	3.480.0
EUR 🇪🇺	3.420.0	3.450.0
CNY 🇨🇳	484	487
RUB 🇷🇺	53.60	54.20
JPY 🇯🇵	24.20	24.60
KRW 🇰🇷	2.46	2.50

### ЗУРХАЙ



**НАМРЫН ДУНД САРЫН ШАРАГЧИН ТАХИА САР ДОЛООН УЛААН МЭНГЭТЭЙ УЛААГЧИН ТАХИА ӨДӨР**

Үс засуулбал:

Өнгө зүс доройтно

НАРАН УРГАХ, ШИНГЭХ:

07.05-18.13

Барилдлага:

Хүчин төгсөх

Шүтэн барилдлага:

Хурьцахуй

## ХОРВОО ЕРТӨНЦИЙГ ХАРАХ ӨНЦӨГ МИНЬ ӨӨРЧЛӨГДСӨН

Нутаг нутгийн олон аавын хөвгүүд өрсөлдсөн "Цэргийн мэргэжлийн аварга түрүүч, байлдагч" шалгаруулах тэмцээний байлдагчийн төрөлд тэргүүн байрыг Зэвсэгт хүчний 327 дугаар ангийн байлдагч Т.Баянмөнх эзлэв.

Байлдагч Т.Баянмөнх баярын сэтгэгдлээ хуваалцахдаа "Шилдгийн шилдэг дайчдаас тэргүүлж чадсандаа үнэхээр баяртай байна. 650 километрийн цаанаас зорьж ирсэн үйлс маань бүтсэн нь ангийн хамт олны хүч хөдөлмөр гэж хэлнэ. Би Дорнод аймгийн Баяндун сумынх. Аав Д.Төмөрбат, ээж Д.Баярмаа нар маань нутагтаа аж төрөн амьдарч байгаа. Ангийнхандаа очиж шагналаа харуулна гэж бодохоор сайхан байна. Цэргийн албанд ирснээр хорвоо ертөнцийг харах нүд минь өөрчлөгдөв. Хамгийн эхэнд бие сэтгэл минь өөрчлөгдлөө. Ээжээрээ "Чи тэрийгээ хийгээч, энийгээ хийгээч" гэж шамдуулж байж нэг юм хөдөлдөг байсан цэргийн албанд ирснээрээ зохион байгуулалттай, эмх цэгцтэй байх нь өөрт ямар амар болохыг мэдэрдлээ. "Утас шагайхаа болиоч" гээд ээжээрээ бас л үглүүлдэг байсан бол энд ирээд нийгмийн сүлжээ дэх элдэв мэдээллээс илүү эх орноо хайрлах нь, түүний үнэ цэнийг мэдрэх нь илүү сайхан болохыг ухаарлаа. Хал нь гаднаа, хайр нь дотроо гэдгийг цэргийн дарга нараасаа олж харлаа. Бие бялдрын хувьд ч ялгаагүй. Гар дээр



хорь ч суниаж чадахгүй, биеэ оторлосон залуу байсан бол өнөөдөр бие бялдар мэдэгдэм өөрчлөгдөж, эрүүл, чийрэг сайхан болж байгаа минь өөрт мэдрэгдэж байна. Эр зориг, тэсвэр хатуужил, хүндлэл

гэж яг юу болохыг цэргийн алба л надад ойлгууллаа" хэмээн бахархан дурслаа. Тэр бас энэхүү тэмцээнээс "Онц буудагч" тэмдгээр шагнуулсан байлаа.

Түүний он-жав дэд түрүүч

Ц.Бат-Орчлон нийслэлийн Баянзүрх дүүргийнх. Зүүн хязгаарт хугацаат цэргийн алба хаах нь түүний мөрөөдөл байжээ. Дэд түрүүч маань "Цэргийн алба миний бодож байснаас ч илүү сайхан юм байна. Эр хүн бүрийн хаах ёстой алба юм байна гэдгийг өөрийн биеэр мэдэрдлээ. Ямар нэгэн сиймхий гарган зугтаадаг залуус байвал та нар зүгээр л хүрээд ир. Ямар сайхан гээч. Олон аавын хөвгүүдтэй мөр зэрэгцээд алба хаахад таны үзэл санаа төлөвшиж, бие бялдар хөгжих болно. Хамгийн гол нь эх орноо бид л хамгаалах ёстой гэсэн үүргээ ойлгоно доо. За тэгээд, цэрэг гэхээр л зөвхөн гүйж харайхын нэр биш юм билээ. Цэргийн өндөр мэдлэгтэй, тактик боловсруулахдаа гаргуун, тэсвэр хатуужил, эр зоригтой, бие бялдрын өв тэгш хүмүүжилтэй гээд маш өндөр шалгуур тавигддаг юм байна. Энэ бүхнийг сурахын төлөө хичээлээ" гэсэн юм.

Энэхүү нийтлэл цаасанд бууж байх агшинд Зэвсэгт хүчний 327 дугаар ангийн удирдлага "Цэргийн мэргэжлийн аварга түрүүч, байлдагч" тэмцээнд тэргүүлсэн байлдагч, түрүүч нараа хамт олныхоо өмнө хүндэтгэлтэйгээр угтан авч, шагнаж урамшуулсан байв. Ангийн захирагчийн тушаалаар байлдагч Т.Баянмөнхөд дэд түрүүч цол, дэд түрүүч Ц.Бат-Орчлонд түрүүч цол олгож, тэдний аав, ээжид талархлын захидал илгээжээ.

АХМАД Д.БОЛОР

Тухайн өдөр могой, морь, гахай, хулгана жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба бич, тахиа жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Өдрийн сайн цаг нь хулгана, бар, туулай, морь, хонь, тахиа болой. Элэдөр буян үйл үйлдвээс өлзийтэй, өргөл хүндлэл, бурханд соёрхол тавих, амирлуулах, дэлгэрүүлэх, эрхшээх үйл нигууд бүтээхэд сайн, бурханы үйл, хувцас хийхэд сайн. Зүүн нүд татвал хувцас олох, баруун чих цангинавал үзэсгэлэн болох, зүүн нь бол үхэл болсныг сонсох, нохой уливал сонсголонтой үг сонсох, тагнай загатнавал гэр арвидах, бие татвал 1-2 хүн ирэх, хөл татвал гомдол аюул болно.

### КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол

Нийт: 627,101,529

Эдгэрсэн

Нийт: 606,882,398

Нас барсан

Нийт: 6,562,295

Цаг үе, үйл явдал

## ТЭРБУМ МОД ТАНЫ ТАРИХ НЭГ МОДНООС ЭХЭЛНЭ



Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар хэрэгжүүлж буй "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд Батлан хамгаалах салбар, Зэвсэгт хүчин тэргүүлэх үүрэгтэйгээр оролцож, 2022-2030 онд 27 сая мод тарьж ургуулан ногоон орчин бий

болгох зорилт тавин ажиллаж байгаа билээ. Уг зорилтын хүрээнд Тусгай хүчний цэргийн гэрээт албанд элсэхээр суралцаж буй бие бүрэлдэхүүн өнгөрөгч амралтын өдөр буюу 10 дугаар сарын 8-нд бүх нийтийн мод тарих үндэсний өдрөөр Зэвсэгт

хүчний 350 дугаар ангийн байрлалд 100 ширхэг гацуур тарьлаа. Цэргийн гэрээт алба хаагчдын хувьд хугацаат цэргийн албанд байхдаа мод тарьж байсан туршлагатай бие бүрэлдэхүүн байлаа.

**Х.УНДАРМАА**

## САЙН ҮЙЛСИЙН АЯНД НЭГДЭХИЙГ УРИАЛЖ БАЙНА



Бидний хайрт охин Баттүвшин овогтой Мөнхзул нь 2019.01.17нд эрүүл саруул төрсөн боловч нярайн шарлалт хүндэрч комд орж тархины саажилт, хатингаршил дөрвөн мөчний чангарал, таталттай болсон. Сүүлийн үед таталт хүндэрч ч байнга татах болсоноор тархины үхжил улам нэмэгдэж, гар хөлний хөдөлгөөны чадвар хоног хугацаа өнгөрөх тусам улам алдагдаж зовиур өвдөлт нь нэмэгдэж байгаа тул тайвшруулах тариа эмний хэрэглээтэй өдөр хонгийг өнгөрүүлж байна бид охиныхоо өвчний материалыг энэтхэг улсын AAKASH нарийн мэргэжилтний эмнэлэгт явуулж таталтыг хяналтанд авч доод мөчний резотомо буюу мэдрэлийн ёзоор таслах болон хоёр гарын шөрмөс сунгах хагалгаануудыг хийлгэснээр охин маань чангарал таталтгүй болж цаашид эрчимтэй хөдөлгөөн засах эмчилгээнд явсаар сууж явах боломжтой болно гэсэн хариу авч үнэхээр баяртай байна. Уг эмчилгээний нийт зардал 110сая төгрөг болох бөгөөд бид бүх боломжоо шавхан 40%-ыг бүрдүүлж чадсан. Үлдсэн мөнгийг олох боломжгүй байгаа тул ах дүү, найз нөхөд, мөрдөс нэгт албан хаагчид монголын сайхан сэтгэлт ард түмнээсээ хандивийн гараа сунган туслаач гэж чинь сэтгэлээсээ гуйж байна.

Буян тань буцаад ирэхдээ Будаа мэт үржих болтугай.

Хандивийн данс: Хаан банк 5779009614  
Аав: Ш.Баттүвшин-91887525  
Ээж: Э.Чинтугалаг-90857595



Зэвсэгт хүчний өргөхийн зэрэгцээ Зэвсэгт 340 дүгээр ангийн хамт хүчний мөрдөс нэгт алба олон "Тархины саажилт хатангирил" хэмээх аян"-д нэгдэхийг уриаллаа. Хүнд өвчинтэйгөө тэмцэж буй бэлтгэл ахлах ахлагч Ш.Баттүвшиний бага охин Б.Мөнхзулын эмчилгээний зардалд сэтгэлийн хандивыг Сайн үйлс бүхэн дэлгэрэх болтугай.

**Д.УЯНГАА**

## НАЯН НАСНЫХАА ОЙГ ТЭМДЭГЛЭСЭН НАЙДВАРТАЙ ХУРАНДАА



Монголын Ардын Арми нэртэй үеэс бүхий л амьдралаа эл салбартаа зориулсан, Улс төрийн ахмад ажилтан, чөлөөнд байгаа хурандаа Рэнцэнгийн Равдандоржийн 80 насны ойг намрын дунд сарын шинийн 15-ны билигт сайн өдөр өргөн дэлгэр тэмдэглэн өнгөрүүлжээ.

Р.Равдандорж нь салааны захирагчаас Хорооны Улс төрийн орлогч хүртэлх албан тушаалд ажиллаж улмаар тухайн үеийн ЗХУ-ын Москва хотын Цэрэг, улс төрийн академийг дүүргэсэн өндөр мэдлэг боловсролтой, аливаа даалгасан ажлыг найдвартай гүйцэтгэдэг, хөдөлмөрч шилдэг офицеруудын нэг юм.

## ЦЭРГИЙНХЭН ЭРХ ЗҮЙН МЭДЛЭГЭЭ ДЭЭШЛҮҮЛЭХЭД ИЛҮҮ ХЯЛБАР БОЛЖЭЭ



Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний тухай хуулиуд

шаардлагын дагуу Зэвсэгт хүчний Программ хангамжийн төвийн дарга, дэд хурандаа С.Даариймаа, тус төвийн системийн инженер, программ зохиогч, ахлах дэслэгч Д.Давааням, программ зохиогч, дэслэгч Д.Ууганбат нар зохион бүтээж, та бидний гар дээр бэлэн болгов.

Тэр апплейкшныг яаж татаж авах вэ, энэ ердөө амархан. Гар утасныхаа App store, Google Play Store програмуудын хайх хэсэгт "ЦАХ-ийн эрх зүй" гэж бичихэд ЗХЖШ-ын лого бүхий "ЦАХ-ийн эрх зүй" гэсэн нэртэй апплейкш гарч ирнэ. Гарч ирсэн даруйд нь QR кодыг уншуулах эсвэл интернэт банкаа ашиглан 2500 төгрөгийн төлбөр төлөхөд л тэгээд таны гарт. Нэгэнт гар утсанд суурилуулсан тохиолдолд хууль, эрх зүйн актууд, холбогдох дүрэм журмууд, бүрээ бөмбөрийн аяз хүртэл үнэгүй гэсэн үг.

Эндээс та төрийн нууцын зэрэглэлд хамаарахаас бусад төрийн албаны хууль, дүрэм журам болон батлан хамгаалах салбарын хэмжээнд дагаж мөрддөг цэргийн албаны

хууль, тогтоомж, эрх зүйн баримт бичгүүдийг цахим хэлбэрээр унших боломжтой.

Хамгийн сүүлд гэхэд Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2022 оны 09 дүгээр сарын 29-ний өдрийн 180 дугаар зарлигаар батлагдсан "Монгол Улсын цэргийн нийтлэг дүрмүүд"-ийг оруулсан байна. Цэргийн дотоод албаны дүрэм, Цэргийн хүрээний ба харуулын албаны дүрэм, Цэргийн жагсаалын дүрэм, Цэргийн сахилгын дүрэмд орсон өөрчлөлтүүдийг уншиж судлахад илүү дөхөм болжээ.

Хэрэв танд ойлгомжгүй санагдвал гар утасныхаа дугаараар бүртгэл хийгдсэний дараа "Анхга" заавар"-тай танилцахаас гадна өөрийнхөө цэргийн хэргийн мэдлэгийг тестүүдээр шалгаж, бүрээ бөмбөр буюу "Тугийн дор", "Анхаар", "Цуглар", "Хоолондоо", "Туяа" зэрэг 17 аязыг гар утаснаасаа шууд тоглуулахаар бүтээгдсэн байна.

Таны эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэхэд илүү хялбар болгон бүтээсэн энэхүү апплейкшныг гар утсанд яг одоо татаарай.

**Ахмад Д.БОЛОР**

СУРГАЛТ

## МОНГОЛ БИЧГИЙН ХИЧЭЭЛ №02

Үсэг бүрдүүлэгч үндсэн махбодоо үргэлжлүүлье.

2. ШҮД

Монгол бичигт хамгийн элбэг тохиолддог. Эгшиг А, Э болон гийгүүлэгч Ха, Га зэрэг хэд хэдэн үсгийн бүрдүүлэгч юм. Уншигч та, шүд махбодыг нуруу буюу босоо шугам дээрээс эхлүүлэн урагш богино, 45 хэмийн налуутай зураас байдлаар гаргаж, буцааж гаргасан зураасаараа нуруундаа зайгүй нийлүүлээд доош нуруугаа үргэлжлүүлэн татах дарааллаар, үзгээ салгалгүйгээр, давтан бичээрэй.

Дармалаар:

Бичмэлээр:

